



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/232

Есөнбулаг сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 22, 23 дугаар зүйл, 39 дүгээр зүйлийн 39.1.1 дэх заалт, 39.2 дахь заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.1 дэх заалт, 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 37 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хамтын шийдэл-хамгаалагдсан ирээдүй" хүүхдийн хөгжил, хамгааллын хөтөлбөрт тусгагдсан үе тэнгийнхний хэвийн бус харилцаа, дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх, сургалт, сурталчилгаа нөлөөллийн ажил зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:
Гишүүд:

(Нийгмийн салбарын төслийн удирдагч)
(Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
(Аймгийн Боловсролын газрын дарга)
(Аймгийн Цагдаагийн газрын дарга)
(Аймгийн Цахим шилжилт, үйлчилгээний хэлтсийн дарга)
(Насан туршийн суралцахуйн төвийн захирал)
(Сумдын Засаг дарга нар)
(Ерөнхий боловсролын сургуулийн захирал нар)

Нарийн бичгийн дарга: Б.Алтайбаатар (Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын дарга)

2. Үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх ажлын нэгдсэн төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ЧИНБАТ

